


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 106

№ 127 0316

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитаар барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4-т /барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах/, Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 170 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.12-т /улсын болон орон нутгийн тосов, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно/, Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах арга хэмжээний" тухай А/407 дугаар захирамжийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийн хяналтын гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллах;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх арга хэмжээ зохион байгуулж, биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹ ирүүлэхийг Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг дарга С.Бат-Оргил, нягтлан бодогч Ц.Ууганбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР  Т.БАТСАЙХАН

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Сайнцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сан
 Тайлант хугацаа: 2022 оны 4 дүгээр улирал

№	Ажил гүйцээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
1	Зардал	Барилга инженерий сүлжээний ажлын хяналтын байгуулаагүй, тавьж ажиллаагүй	-	Албан шаардлага хүргүүлэх	Засаг дарга С.Бат-Оргил, Засаг даргын орлогч И.Эрдэнэцог Нягтлан бодогч Ц.Ууганбаяр нарт 2023 оны 02 дүгээр сарын 15-ны танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн	Барилгын тухай хууль, Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн “Барилгын ажил эхлүүлэх, Үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах арга хэмжээний” тухай А/407 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж захиалагчийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллах	Зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн	Засаг дарга, Засаг даргын орлогч Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	С.Бат-Оргил И.Эрдэнэцог Ц.Ууганбаяр
2	Зардал	Аймгийн ОНХС-аас авах авлагыг сумын ОНХС-ийн тайланд тусгаагүй.	19,800,000.0	Залруулах	Засаг дарга С.Бат-Оргил, Засаг даргын орлогч И.Эрдэнэцог Нягтлан бодогч Ц.Ууганбаяр нарт 2023 оны 02 дүгээр сарын 15-ны танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн	2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруула хийх	Тооцоо нийлсэн актаар баталгаажуулж залруулга хийсэн.	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	С.Бат-Оргил И.Эрдэнэцог Ц.Ууганбаяр

3	Бараа материал	Малжуулах төслийн малыг ОНХС-ийн бараа материал дансанд бүртгэсэн	127,214,000.0	Залруулах	Засаг дарга С.Баг-Оргил, Засаг даргын орлогч И.Эрдэнэцог Нягтлан бодогч Ц.Ууганбаяр нарт 2023 оны 02 дүгээр сарын 15-ны танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн	2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулга хийх	2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулга хийсэн.	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	С.Баг-Оргил И.Эрдэнэцог Ц.Ууганбаяр
		Нийт дүн	147,014,000.0						

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Хянасан: Аудитын менежер

Хоёр дах шатанд хянасан: Дарга гэрэгүүлэх аудитор

Т.Багсайхан

Х.Наранцацрал

Р.Мөнхтогтох

Засаг дарга

Засаг даргын орлогч

Нягтлан бодогч

С.Баг-Оргил

И.Эрдэнэцог

Ц.Ууганбаяр

